



Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын
2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн
06/143 дугаар албан бичгийн хавсралт

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ НИЙСЛЭЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ”-ИЙН
2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНД НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР,
СПОРТЫН ГАЗАР ХАРИУЦАН ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ

2024 оны 06 дугаар сарын 06

Улаанбаатар хот

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түшин | Хүрэх түвшин | Биелэлт | Хэрэгжилт (хувь) |
|--|--|-------------------|-------------|--------------|---|------------------|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| НЭГ. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН ДЭД БОЛОН САЛБАР ЗӨВЛӨЛӨӨС ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ | | | | | | |
| 1 | 8. Дүүргийн соёлын төв, спорт заалыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нээлттэй болгож, тэднийг спорт, соёл, урлагаар хичээллэх боломжийг хангах, дугуйлан, секцэд хамруулах, төрөл бүрийн спорт, урлаг, соёлын уралдаан, тэмцээн зохион байгуулахад заал, танхимаар хангах | Хэрэгжилтийн хувь | 100 | 100 | Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг биеийн тамир, спортоор хичээллэх нөхцөл боломжийг бүрдүүлэх чиглэлээр спорт заал, спортын зориулалтын талбайг нээлттэй болгож үнэгүй цаг гаргаж өгөх секц дугуйланг шинээр байгуулахад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх зөвлөмж өгч нийслэлийн 9 дүүргийн Биеийн тамир, спортын хороонд албан тоотоор хүргүүлж ажиллаа. Дээрх ажлын хүрээнд нийслэлийн Чингэлтэй, Сонгинохайрхан, Баянгол, Багануур, Багахангай дүүргийн Биеийн тамир, спортын хороод ашиглалтыг нь хариуцаж байгаа 3 спорт цогцолбор, 3 спорт зааланд үнэ төлбөргүйгээр 7 хоног бүр тодорхой хуваарьт цаг | 90% |

| | | | | | | |
|---|--|-------------------------|-------------------------|--|--|---------------------------|
| | | | | | <p>гарган нийт 147 хүнд тогтмол үйлчилгээ үзүүлж байна.</p> <p>Мөн Даам, Хонхот бөмбөг, Пара бочи, Хэрэглэлтэй сэлэм, бялдаржуулах төв, суугаа волейбол, ширээний теннис зэрэг 9 секц дугуйлан шинээр байгуулагдан 110 хүнийг тогтмол хичээллүүлж байна.</p> | |
| <p align="center">ХОЁР. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНД ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД:</p> | | | | | | |
| <p>2</p> <p>10.Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг спортоор хичээллэх боломжийг бүрдүүлэх, тэднийг идэвхжүүлэх спортын өдөрлөг, тэмцээн уралдааныг зохион байгуулах</p> | <p align="center">Арга хэмжээний тоо</p> | <p align="center">4</p> | <p align="center">5</p> | | <p>Нийслэлийн хэмжээнд нийслэл болон 9 дүүргийн Биеийн тамир, спортын хороодоос тус бүр хөгжлийн бэрхшээлтэй хүнийг биеийн тамир, спортын тэмцээн, уралдаанд тэгш хамрагдуулах үйл ажиллагааны төлөвлөгөө гарган 2024 оны эхний хагас жилийн байдлаар нийт 25 арга хэмжээ зохион байгуулж давхардсан тоогоор нийт 242 байгууллагын 1710 хүн хамрагдаад байна.</p> <p>Үүнд: Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээний хуваарьт Хонхот бөмбөг, Пара бочи, Пара бадминтоны төрлөөр зохион байгуулахаар төлөвлөснөөс Нийслэлийн Биеийн тамир, спортын газар, Монголын Хонхотой бөмбөгийн холбоотой хамтран Улаанбаатар хотын 2024 оны аварга шалгаруулах Хонхот бөмбөгийн тэмцээнийг 2024 оны 05 дугаар сарын 18-19-ний өдрүүдэд зохион байгуулж 9 байгууллагын 45 тамирчдыг хамруулсан. Бусад 2 тэмцээнийг 4-р улиралд зохион байгуулахаар төлөвлөж бэлтгэл ажил 80 хувьтай хэрэгжиж байна.</p> <p>“Улаанбаатар марафон 2024” олон улсын гүйлтийг 2024 оны 05 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулсан. Тус гүйлтийн төрөлд тусгай олимпын 500 м, 800 м -ийн ангиллыг нэмж шаардагдах санхүүжилтийг төсөвт тусган</p> | <p align="right">90 %</p> |

| | | |
|---------------------------|--|-----|
| | <p>хэрэгжүүлээ. Ингэснээр тус марафонд нийт 7 ангилалд буюу тусгай олимпын төрөл 500 м -т 36 хүн, 800 м -т 20 хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэд 1500 м -ийн зайд (хараагүй) 34 хүн, (тэргэнцэртэй) 17 хүн, 21,095 км -т 30 тамирчин, 42,195 км -т 10 тамирчин, гар дугуйн ангилалд 5 тамирчин нийт 152 хүн оролцлоо. “Улаанбаатар марафон 2024” олон улсын гүйлтэд тусгай хэрэгцээт болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төрөл, шагналын төсвийг нэмэгдүүлж тэгш оролцоог хангаж өгснөөр энэ төрөлд оролцсон хүүхэд, залуучууд, иргэдээс талархал хүлээсэн үр дүнтэй ажил боллоо.</p> | |
| Хэрэгжилтийн дундаж хувь: | | 90% |

ХЯНАСАН:
СПОРТ, НИЙТИЙН БИЕИЙН ТАМИРЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



Г.САРАНЦЭЦЭГ

Г.БЯМБАСАЙХАН